



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯНМӨНХ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 03 сарын 20 өдөр

Дугаар А/22

Улаан эрэг

Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх,
тэмцэх арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Ойн тухай хуулийн 18-р зүйлийн 18.2.1, 18.2.12, 18.2.14 дэх заалт, Галын аюулгүй байдлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1, 14.1.4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, 32.1.8, 32.1.10 дахь заалт, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1 дэх заалт, аймгийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 23-ны 01 дүгээр албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хуурайшилтын үед хөдөө хээр ажил үйлчилгээ явуулах, байгалийн дагалдах нөөцийг ашиглах, аялал зугаалгаар явах, бусад үйл ажиллагааг 03 дугаар сарын 20-ноос 6 дугаар сарын 10, 9 дүгээр сарын 20-ноос 11 дүгээр сарын 10-ны хооронд хязгаарласугай.

2.Ард иргэдэд аялал зугаалгаар явахдаа болгоомжтой, сонор сэрэмжтэй байх, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа, яриа таниулга хийж, баталгаа гаргуулахыг багийн Засаг дарга нарт даалгасугай.

3.Сургалт сурталчилгааны ажлыг чанартай зохион байгуулж, захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (А.Болормаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.НЯМДАВАА